



УЛААНБААТАР  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 6/488

Улаанбаатар хот

А.Баяртогтохыг ажлаас чөлөөлж,  
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.2, 40 дүгээр зүйлийн 40.1.3, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хангамж үйлчилгээний албаны сахиул Авирын Баяртогтох /121397/-ыг 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. А.Баяртогтоход эрчим хүчний салбарт 14 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 18 816 000 /арван найман сая найман зуун арван мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгох, ээлжийн амралтын олговрыг 41.14 хоногоор тооцож олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

3. А.Баяртогтохын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилж, ажлыг 3 өдөрт багтаан хүлээлцүүлж холбогдох тооцоог хийж дуусгахыг комиссын дарга Б.Ялгуунд үүрэг болгосугай.

Комиссын дарга:

Б.Ялгуун - Хангамж үйлчилгээний албаны ахлах мэргэжилтэн /аж ахуй, үйлчилгээ хариуцсан/

Гишүүд:

С.Батсаяа - Хангамж үйлчилгээний албаны инженер /инженерийн байгууламж, харуул хамгаалалт хариуцсан/

С.Цэвэлмаа - Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч /үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын/

Ц.Алтанцэцэг - Санхүү бүртгэлийн хэлтсийн нярав /үндсэн хөрөнгө авто-сэлбэгийн/

e:\2021 он\ashiglalt-2\зхнх\тэтгэвэрт гаргах.docx

3170602909

2.

Р.Цэрэннадмид-Санхүү бүртгэлийн хэлтсийн нярав /сэлбэг материалын/  
Б.Хулан-Өндөр хүчдэл түгээх төвийн ахлах нягтлан бодогч  
Б.Бадамцэцэг-Өндөр хүчдэл түгээх төвийн нярав /мөнгөн хөрөнгө,  
материалын/

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн  
хэлтсийн дарга /Б.Баттушиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН